



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Тэшиг сумын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/45/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.bulgan@audit.gov.mn Булган аймаг Булган сум 2023 он	Булган аймаг дахь ТАГ-н дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 89009802 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Утас: Цахим хаяг: Аудитор: Б.Золжаргал Утас: 90119931 Цахим хаяг: zoliargalb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.14 № 95
танай _____ ны № _____ т

ТЭШИГ СУМЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Г.СҮХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тэшиг сумын ИТХ-н 08 дугаар хуралдааны 21-р тогтоолоор Ойн ангийн 2022 оны үйл ажиллагааг дарга-1, инженер-1, нягтлан бодогч-1 орон тоотойгоор, 33.7 сая төгрөгөөр төсөвлөж батлуулсан. Гэвч тусгаарлалтын орлогын төлөвлөгөөг төсөвлөж, батлагдсан дүнгээс 5.0 сая төгрөгөөр дутуу гэрээ хийж, гэрээний дүнгээс 2.4 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлж авлагаар тусгасан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

D:\bichighereg\2022A4\toot

006020102

Бусад асуудлын хэсэг

2022 онд байгаль хамгаалагч Ж.Мөнхбат, Б.Төмөртоогоо, М.Дэмбэрэлдаш, Г.Батжүгдэр нартай талбай тусгаарлалтын гэрээг хийсэн боловч тайлант хугацааны эцэст гэрээг дүгнэж, тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,787,716.88	7,793,190.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,167,826.88	3,010,085.29
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,167,826.88	3,010,085.29
3121	Төгрөг	1,167,826.88	3,010,085.29
31213	Арилжааны банк дахь харилцах	1,167,826.88	3,010,085.29
33	АВЛАГА	2,619,890.00	4,692,705.60
335	Бусад авлага	2,619,890.00	4,692,705.60
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,619,890.00	4,692,705.60
35	БАРАА МАТЕРИАЛ	-	90,400.00
354	Хангамжийн материал	-	90,400.00
35410	Бичиг хэргийн материал	-	55,500.00
35470	Бусад хангамжийн материал	-	34,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	4,399,800.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	4,399,800.00
392	Биет хөрөнгө	-	4,399,800.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	4,399,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,787,716.88	12,192,990.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	78,000.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	78,000.60
413	Өглөг	-	78,000.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	78,000.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,787,716.88	12,114,990.29
51	Засгийн газрын хувь оролцоо	3,787,716.88	12,114,990.29
512	Хуримтлагдсан үр дүн	3,787,716.88	12,114,990.29
51210	Өмнөх үеийн үр дүн	3,787,716.88	3,787,716.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	8,327,273.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,787,716.88	12,192,990.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,947,500.00	30,530,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,947,500.00	30,530,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,947,500.00	30,530,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,947,500.00	30,530,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,947,500.00	28,725,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,805,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,159,783.12	22,202,726.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,159,783.12	22,202,726.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,159,783.12	22,202,726.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,873,247.38	18,214,636.52
210101	Үндсэн цалин	13,873,247.38	18,214,636.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,823,415.74	2,295,552.90
210201	Тэтгэврийн даатгал	1,268,485.87	1,566,816.18
210202	Тэтгэмжийн даатгал	138,732.47	182,184.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	110,985.97	145,747.36
210204	Ажилгүйдлийн даатгал	27,746.49	36,436.83
210205	Эрүүл мэндийн даатгал	277,464.94	364,368.35
2104	Хангамж, бараа материалын зардал	450,800.00	1,260,660.00
210401	Бичиг хэрэг	158,000.00	262,000.00
210402	Тээвэр, шатахуун	292,800.00	998,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	34,900.00
210604	Урсгал засвар	-	34,900.00
2107	Томилолт, зочны зардал	-	244,000.00
210702	Дотоод албан томилолт	-	244,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	152,977.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	137,877.17
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	15,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,320.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,320.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,787,716.88	8,327,273.41
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,787,716.88	8,327,273.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	17,327,610.00	<u>28,535,185.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,327,610.00	28,535,185.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,327,610.00	28,535,185.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,327,610.00	28,535,185.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,327,610.00	26,730,185.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,805,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	16,159,783.12	<u>22,293,126.59</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,159,783.12	22,293,126.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,159,783.12	22,293,126.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,873,247.38	18,214,636.52
210101	Үндсэн цалин	13,873,247.38	18,214,636.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,823,415.74	2,295,552.90
210201	Тэтгэврийн даатгал	1,268,485.87	1,566,816.18
210202	Тэтгэмжийн даатгал	138,732.47	182,184.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	110,985.97	145,747.36
210204	Ажилгүйдлийн даатгал	27,746.49	36,436.83
210205	Эрүүл мэндийн даатгал	277,464.94	364,368.35
2104	Хангамж, бараа материалын зардал	450,800.00	1,316,160.00
210401	Бичиг хэрэг	158,000.00	317,500.00
210402	Тээвэр, шатахуун	292,800.00	998,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	69,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	69,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	244,000.00
210702	Дотоод албан томилолт	-	244,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	152,977.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	137,877.17
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	15,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,320.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,320.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,167,826.88</u>	<u>6,242,058.41</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,399,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,399,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,399,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,399,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	<u>(4,399,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,167,826.88	1,842,258.41
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,167,826.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,167,826.88	3,010,085.29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-		-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-		-
C08	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	3,787,716.88	-	3,787,716.88
D01	2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	3,787,716.88	-	3,787,716.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	3,787,716.88	-	3,787,716.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	8,327,273.41		8,327,273.41
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	12,114,990.29	-	12,114,990.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,750,000.00	26,692,926.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,750,000.00	22,293,126.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,750,000.00	22,293,126.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,519,978.00	18,214,636.52
210101	Үндсэн цалин	18,519,978.00	18,214,636.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,352,037.00	2,295,552.90
210201	Тэтгэврийн даатгал	1,605,510.03	1,566,816.18
210202	Тэтгэмжийн даатгал	186,631.74	182,184.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	149,305.41	145,747.36
210204	Ажилгүйдлийн даатгал	37,326.34	36,436.83
210205	Эрүүл мэндийн даатгал	373,263.48	364,368.35
2104	Хангамж, бараа материалын зардал	1,600,000.00	1,316,160.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	317,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	998,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,566,363.00	69,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	69,800.00
210604	Урсгал засвар	5,566,363.00	-
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	244,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	244,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,622.00	152,977.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,622.00	137,877.17
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	15,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	4,399,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	4,399,800.00
222001	Тоног төхөөрөмж	5,000,000.00	4,399,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,725,000.00	28,535,185.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	28,725,000.00	28,535,185.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,725,000.00	26,730,185.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,805,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,167,826.88
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,010,085.29

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэшиг сумын Ойн ангийн 2022 оны үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрлэлийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад чиглэгдэнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Ойн тухай хууль, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль зэрэг бусад эрх зүйн акт, тогтоомжуудыг мөрдөж ажилладаг

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөж ажиллаагүй байна.

Дотоод аудитын ажилтангүй, дотоод хяналтын ажил төлөвлөж ажиллаагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэшиг сумын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккуруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан "Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажилладаг. Үйл ажиллагаанд нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэшиг сумын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.4 сая төгрөгөөр буюу 222 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,167.8	3,010.1	1,842.2
Авлага	2,619.8	4,692.7	2,072.8
Бараа материал	0.00	90.4	90.4
Үндсэн хөрөнгө	0.00	4,399.8	4,399.8
Нийт хөрөнгө	3,787.7	12,192.9	8,405.2
Өр төлбөр	0.00	78.0	78.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,787.7	12,114.9	8,327.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,787.7	12,192.9	8,405.2

Дээрх хүснэгтээс харахад:

- ✓ Авлага өмнөх оны үлдэгдлээс 411.2 мянган төгрөгөөр төлөгдөж, энэ онд талбай тусгаарлалтын төлөгдөөгүй авлага 2,406.04 мянга, ХХОАТ илүү хөнгөлснөөс үүссэн авлага 78.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- ✓ Ажлын хэрэгцээнд 2 ширхэг зөөврийн компьютер худалдаж авч үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд тусгасан байна.
- ✓ Цалингийн ашиг илүү хөнгөлснөөс 78.0 мянган төгрөгийн дутуу төлөлтөөс өглөг 78.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг талбай тусгаарлалтын орлогоос 33,700.0 мянган төгрөг, үндсэн болон урамшуулалт цалин 17,389.5 мянга, ажил олгогчоос төлөх НДШ 2,352.0 мянга, дотоод албан томилолт 700.0 мянга, түлш, шатах тослох материал 1,000.0 мянга, тоног, төхөөрөмжийн зардал 5,000.0 мянга, бичиг хэргийн зардал 600.0 мянга, урсгал засварын зардал 5,566.3 мянган төгрөгийн зардал төлөвлөж сумын Засаг дарга, ИТХ-д хүргүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг сумын ИТХ-ын 2022 оны 8-р хуралдааны 21-р тогтоолоор 33,700.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 33,700.0 мянган төгрөгийг талбай тусгаарлалтын орлогоос бүрдүүлэхээр төсөвлөсөн.

Орлогын гүйцэтгэл 28,535.2 мянган төгрөг ба тодруулбал, өмнөх оны талбай тусгаарлалтын авлага 411.2 мянган төгрөг, самрын орлого 1,800.0 мянган төгрөг, тайлант оны талбай тусгаарлалтын орлого 26,323.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орлогын төлөвлөгөө 22 хувь буюу 7,4 сая төгрөгөөр тасарсан нь дөрвөн байгаль хамгаалагч, иргэнд 47 удаагийн талбай тусгаарлалтын гэрээгээр 28,725.0 мянган төгрөгийн, аж ахуйн нэгжтэй талбай тусгаарлалтын гэрээ хийсэн боловч талбай тусгаарлалтын гэрээний дагуу байгаль хамгаалагчтай тооцоо хийж гэрээний

биелэлтийг хангуулж, дүгнэж, орлого бүрдүүлэлтэд анхаарч ажиллаагүй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орлого	33,700.00	28,535.18	5,164.82	84.6%
	Зарлага	33,700.00	22,293.12	11,406.88	66.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Тус ойн анги нь нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэшиг сумын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, талбай тусгаарлалтын орлогыг бодитой тооцоолж байх, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг иж бүрэн, хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь ТАГ-н аудитор Б.Золжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь ТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардал 22,293.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 334.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 234.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Зөвшөөрөлгүй мод бэлтгэх, самарт гарсан иргэдийг шалгах, таслан зогсоох эргүүл хийх ажил, тусгаарласан талбайг хүлээлгэн өгөх акт үйлдэх ажлаар явахдаа байгууллагын эзэмшлийн тээврийн хэрэгсэлгүй учир хувийн тээврийн хэрэгсэлд 631.5 мянган төгрөгийн шатахуун зарцуулж хяналт хийжээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 63 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын даргын гаргасан тушаалын эх хувь байгууллага дээр архивлагдаж үлддэггүй, тухайн тушаалыг 1 хувь үйлдэж холбогдох газар хүргүүлдэг тул шилэн дансны хуулийн хэрэгжилтийн "6.4.8 Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл"-ийг санхүүгийн баримтад хавсаргасан тушаалаар тооцож үзэхэд 6 сард цалин шинэчлэн тогтоосон 895.9 мянган төгрөгийн Б/14 тушаалыг 12 сард хугацаа хоцроож мэдээлсэн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж хүргүүлэх

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд илэрсэн алдаа, зөрчилгүй.

Шийдвэрлэсэн нь:

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар:

- ✓ Тайлангийн иж бүрдэлтэй холбоотой асуудал
- ✓ Авлагын данстай холбоотой асуудал
- ✓ Дотоод ажилтай холбоотой асуудал
- ✓ Дотоод хяналттай холбоотой зэрэг асуудалд зөвлөмж хүргүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0.0				
Албан шаардлага	0.0				
Зөвлөмж	4.0	0.0	1.0	0.0	75%
Нийт дүн	4.0	0.0	1.0	0.0	

Зөвлөмжийн биелэлтийг тооцож үзэхэд тайлант онд талбай тусгаарлалтын орлогын 2,406.0 мянган төгрөгийн авлага нэмж үүсгэсэн нь зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- 1.Талбай тусгаарлалтын орлогыг бодитой зөв тооцоолж, батлуулах
2. Нягтлан бодох бүртгэлийг аккрузель сууриар бүртгэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,920.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс талбай тусгаарлалтын гэрээний дагуу 4 байгаль хамгаалагчаар тооцоо үүсгэж, орлогын дүнгээр тооцоог хааж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулалгүй бөөн дүнгээр авлагаар бүртгэснийг аудитын явцад залруулж, талбай тусгаарлалтын орлого төлөвлөхдөө 5,025.0 мянган төгрөгөөр илүү тооцож батлуулсан, 895.9 мянган төгрөгийн тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Шатахууны зарцуулалтыг шалгахад приус-20, land cruiser-100, corolla axio, prado120, X-trial зэрэг тээврийн хэрэгслийн 100 км-т зарцуулах жишиг нормыг 194.7 мянган төгрөгийн шатахуун хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хэтрүүлэн зарцуулсан 194.7 мянган төгрөгийг аймгийн орлого болгох, төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

Зөвшөөрөлгүй мод бэлтгэх, самарт гарсан иргэдийг шалгах, таслан зогсоох эргүүл хийх ажил, тусгаарласан талбайг хүлээлгэн өгөх акт үйлдэх ажлаар явахдаа байгууллагын эзэмшлийн тээврийн хэрэгсэлгүй учир хувийн тээврийн хэрэгсэлд 631.5 мянган төгрөгийн шатахуун зарцуулж хяналт хийсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Ойн ангийн 2022 оны талбай тусгаарлалтын орлогыг тусгаарлалтын талбайтай уялдуулж төлөвлөөгүй, тусгаарлалтын гэрээний биелэлтийг хангуулж ажиллаагүйгээс орлогын биелэлт 5,025,000.0 төгрөгөөр тасарсан.

Энэ нь Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 "Ойн талбайн хэмжээний нормативыг харгалзан нутаг дэвсгэртээ байх ойн ангийн жагсаалт, тухайн жилийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төсвийг батлах”, Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн “төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага” зэргийг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орлого төлөвлөлтийг тусгаарлалтын талбайн хэмжээнд үндэслэн бодитой тооцоолж, батлуулж байх

2. Шилэн данстай холбоотой асуудлаар

2.1 Илрүүлэлт: Байгууллагын даргын гаргасан тушаалын эх хувь байгууллага дээр архивлагдаж үлддэггүй, тухайн тушаалыг 1 хувь үйлдэж холбогдох газар хүргүүлдэг тул шилэн дансны хуулийн хэрэгжилтийн "6.4.8 Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл"-ийг санхүүгийн баримтад хавсаргасан тушаалаар тооцож үзэхэд 6 сард цалин шинэчлэн тогтоосон 895.9 мянган төгрөгийн Б/14 тушаалыг 12 сард хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг иж бүрэн, хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх зөвлөмж

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого төлөвлөлт	1	5,025.0					1	5,025.0			1	5,025.0
Дүн	1	5,025.0					1	5,025.0			1	5,025.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Норм хэтрүүлэн зарцуулсан	1	194.7	1	194.7								
Дүн	1	194.7	1	194.7								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	1	895.9					1	895.9
Дүн	1	895.9					1	895.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хууль	1	631,5			1	631.5		
Дүн	1	631,5			1	631.5		
Нийт дүн	2	1,527.4			1	631.5	1	895.9